

# Living the LOTUS

Buddhism in Everyday Life



VOL. 164

Үүсгэн байгуулагчийн сургаал

## Зүрх сэтгэлийн гүн дэх тэмүүлэл

Архинаас хамаарах өвчтэй хүн болон хоолны дуршил буурах өвчтэй охидыг харахаар бид “нэгэнт ийм болчихсон хүнийг яагаад ч нэмэргүй, миний хийж чадах зүйл байхгүй” гэж бодчихдог. Гэвч ийнхүү эргэн тойрны хүмүүсээсээ зайгаа барьж байгаа эдгээр хүмүүс нь үнэндээ “Би бол сул дорой хүн учраас намайг чанга тэврээсэй” хэмээн хайрыг хүсэх эрмэлзлээ биеэрээ илэрхийлж байдаг гэж мэргэжлийн эмчээс сонсож байсан удаатай.

Бурхан багш “Хамаг амьтны чин сэтгэлийн үйлийг мэдээд Мэдэгдэл түйтгэргүй болох” эмээжээ. Хүний хэлж, ярьж байгаа нь сэтгэлийн гүнээс хүсч байгаагаасаа ялгаатай байх нь бий. Та бүхэнд ч бусдад эелдэг хандахыг хүссэн хэрнээ өөрийн мэдэлгүй нөгөө хүндээ хүйтэн хөндий хандах, буян хийх хэрэгтэй гэж мэдээд байгаа хэрнээ алхууралдаа дийлдчихдэг тохиолдол

байдаггүй гэж үү?

Ямарч олиггүй муу хэрэг хийсэн хүн байлаа ч сайхан сэтгэлийн хэлтэрхий үгүй байна гэж байдаггүй. Болохгүй гэдгийг нь мэдсээр байж сэтгэл зүрхнээсээ үл хамааран муу зүйлд татагдан, түүнээсээ болж шаналж явдаг тэрхүү сэтгэлийн гүн дэх шаналалыг нь анзаарч харахыг ч хүсэлгүй зөвхөн нүдэнд ил харагдах үг, үйлдлээр нь хүнийг дүгнэж, шүүж болохгүй.

Юун түрүүнд өөрийнхөө сэтгэл зүрхийг гүн гүнзгий нягталж танихгүйгээр бусдын зовлон шаналлыг адилхан мэдрэх боломжгүй. Тийм нигүүлсэл үгүй бол бусдыг аварч эс чадна.

Үүсгэн байгуулагчийн сургаал 9, Х.36-37

### Living the Lotus Vol. 164 (2019,05)

**Хэвлэсэн:** Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

**Хаяг:** Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

**TEL:** +81-3-5341-1124

**FAX:** +81-3-5341-1224

**Email:** [living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp](mailto:living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp)

**Ахлах редактор:** Саитоо Кооичироо

**Орчуулсан:** Ж.Гэрэлтуяа, Б.Мөнхцэцэг

**Эхийг хянасан:** Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

*Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.*

## Зовлон шаналал үл барагдахын учир



Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч  
Нивано Ничикоо



### “Зовлон” ба “Шаналал” -ын ялгаа

Их гай зовлонтой нүүр тулж, ар араасаа шаналж, зовохыг “Дөрвөн зовлон, найман шаналал” гэж хэлдэг ба энэхүү “Дөрвөн зовлон найман шаналал”-ыг Бурханы сургаалын үг хэллэг гэдгээр нь хүмүүс сайн мэднэ.

Энэ хорвоод бүгд мэндэлж, өтөлж, өвдөж, төдөлгүй насан эцэслэдэг жамтай. Энэхүү “Төрөх, өтлөх, өвдөх, үхэх” бол “Дөрвөн зовлон” юм. Түүнчлэн “Хайртай зүйлээсээ хагацахын зовлон (Хайраасаа хагацах зовлон)”, “Хорсолт хүн хийгээд дургүй зүйлтэйгээ учрахын зовлон (Өшөөт хүнд учрах зовлон)”, “Хүсч найдаж байсан нь биелэхгүйн зовлон (Хүссэнээр болохгүйн зовлон),” эд бүгдийн цогц илэрхийлэл болсон “Бие сэтгэлийн үйлээс бий болох зовлон (5 үйлийн хураах зовлон)”-г нэмээд “8 зовлон” болох бөгөөд үүнийг амьдралын “Зовлон” гэж үздэг.

Гэвч Шагжамүни бурхан бээр энэхүү “Зовлон”-г одоогийн бидний түгээмэл хэрэглэдэг “хүнд, хэцүү бэрх зүйл” гэсэн утгаар илэрхийлээгүй бололтой. “Зовлон” гэдэг үгний уг гарал нь “Санаснаар болохгүй байх” гэсэн утгатай “Дүкка”-хэмээх үгнээс гаралтай тул дээрх 8 зовлонгийн аль нь ч “Өөрийн хүчээр хичээгээд нэмэргүй” гэсэн утгыг илэрхийлж буй юм. Гэтэл “яаж ийгээд давах юмсан” хэмээн хүсэж, зовлондоо хэт автаад, бууж өгөхгүй байх аваас сэтгэлд “төвөгтэй юм бэ”, “Хэцүү юм бэ” гэсэн бодол бий болох болно. Тэр л үед “Зовлон” нь бие сэтгэлийг тарчилгах “Шаналгаа” болж хувирдаг.

Энэ мэт хүний амьдралын зовлон шаналлын үл барагдах шинж чанарыг Цагаан Лянхуан Сударт

“Төрөх үхэхийн аюулт мөрд ороод  
Залгамжлан үргэлжилж зовлон үл тасармуй.  
Хүслийн таван эрдэмд гүнээ автах нь  
Сарлаг сүүлэн хайрлахын мэт болой. (Уран аргыг үгүүлэхүй) “Хүсэл шуналдаа автсанаас зовлон зүдгүүр үл барагдна” хэмээн сургаж, улмаар “Олон буруу үзэлд гүнээ автаад Зовлонгоор зовлонг гээсүгэй.” гэсэнчлэн санаснаар болохгүй байгаа бодит байдлыг хүлээж авч чадахгүй болохоороо бухимдан шаналж, зовлон зүдгүүрээ улам гүнзгийрүүлэх бидний сэтгэл зүрхний үнэнг сануулжээ.



## “Зовлон” бол “Билиг оюун” -ын ундрагын эх

Эчигогийн Бидний эргэн тойронд өр зээлнээсээ болж шаналж, энэхүү зовлонгоосоо ангижрах гэсэндээ улам илүү их өр зээлийг бий болгодог гэх яриа их сонсогддог. Энэ нь “зовлонгоор зовлонг гээсүгэй” гэдгийн бодот жишээ бөгөөд дээрх аргаар зовлон шаналал хэзээ ч үл алга болно.

Сайгё номын багш бээр (1118–1190он):  
“Хүсэл тачаалаар өөрийгөө бүтээгээд Харанхуй сохор болоод юуг ч үл үзэх болой.” хэмээн мөр холбож, хүсэл шуналаасаа болж дахин дахин зовох биднээс “Яагаад үргэлж эрхэм чухал зүйлээ анзааралгүй, зүрх сэтгэлээ өөрчлөхийг үл оролдоно вэ” хэмээн шүлгээрээ дамжуулан асуусан байдаг.

Тэрхүү эрхэм чухал зүйл гэдэг нь нүүр тулан ирсэн “Зовлон”-г “Зовлон шаналгаа” хэмээн дэврүүлэн төвөгшөөх бус, “Зовлон”-той учирна гэдэг “Билиг оюун”-аа сэрээх нэгэн боломж хэмээн анзаарах явдал юм.

Шаналал, харуусал гуниг, уур бухимдал хийгээд хэцүү бэрхтэй ч холбогддог “Зовлон” нь өөрөө угтаа бол сайн ч, муу ч зүйл биш бөгөөд хоосон чанартай юм. Харин түүнд бидний сэтгэл хөдлөл нөлөөлдөг болохоор л янз бүрээр дүгнэдэг хэрэг. Тиймээс “зовлон”-г хэрхэн яаж хүлээж авах, хааш нь залахаас хамааран хүмүүсийн амьдралд томоохон ялгаа бий болдог.

Дээр дурдсанчлан хэдэн арван сая иений өр зээлтэй хүн: “Энэ бол надад шаардлага байсан учраас оноогдсон сорилт” гэж хүлээж авсан бөгөөд “Ингэж бодохоор энэ нөхцөл байдал маань зовлон шаналал бус харин намайг хурцлах хүч болдог” хэмээн хөнгөн хөгжүүнээр хэлсэн юм.

“Зовлон”-оос зугтаах бус байгаа тэр чигээр нь хүлээж авах сэтгэлийн бэлтгэл, ухамсартай байж чадвал тэрхүү “Зовлон” нь “Билиг оюун”-ыг тань оргилуулах ундрагын эх болох боломжтой. Бидний төрөлхийн “Билиг оюун”-ыг сэрээхэд “Зовлон” л хэрэгтэй байж хэмээн ухааран хүлээж авбал “Зовлон” нь аз жаргалд хүргэх чухал тэмдэг дохио болж, нэг мэдэхнээ нөгөөх “зовлон” ч арилан алга болох болно.

Үүнийг “Зовлон”-той байлаа ч зовлон шаналгаагүй амьдрал гэж хэлж болох биз ээ. Энэ тухай Бурханы сургаалд “Хутагтын дөрвөн үнэний сургаал” гэх мэтээр сургасан байдаг. Гэвч эдгээр сургаалуудыг сурч ойлголоо ч мөнөөх зовлонтойгоо учрахаараа бид барьц алдан зовж шаналдаг ба энэ үед өөрийгөө буруутгах хэрэггүй. Учир нь зовлон бэрхшээлийг амтлахгүйгээр Бурханы сургаал хэмээх “Аз жаргалд хүргэх зам”-аар алхахгүй ч байж магадгүйн тул тэр билээ.

«Косей» сэтгүүлийн 2019 оны 5 сарын дугаараас





# Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

## Оройн Дээд Цагаан Лянхуа Судар Хувилгаан балгасаар зүйрлэхүйг үгүүлэх 7 дугаар бөлөг



### Амьдралын утга учрыг ойлгох

Энэхүү зүйрлэлийн өнгөц утга нь өмнө тайлбарласан “Гурван тэрэг ба шатаж буй байшингийн зүйрлэл” болон “Баян ноён ба ядуу хүүгийн зүйрлэл”-тэй ижил бөгөөд “Бурханы сургаал бол зөвхөн нэг хөлгөн”, “уран арга нь ч жинхэнэ үнэн мөн” гэсэн хоёр том үндсэн зарчмаас гажихгүй ч дахин дахин сануулж хэлээд байгаа нь цаанаа учиртай. Ямар зорилготой вэ гэвэл “бүтээлчээр амьдрах нь амьдралыг илүү утга учиртай болгоно” гэсэн далд утга агуулагдаж буй бөгөөд түүний төлөө өөрсдийгөө дайчилъя гэсэн санааг илэрхийлж буй хэрэг юм.

Урт, бартаат зам гэдэг нь бидний амьдралын аяллыг илэрхийлнэ. Тэрхүү аяллын дундаас хүндрэл бэрхшээл ар араасаа бий болдог. Хэн ч түүнийг даваад гарахыг хичээдэг ч санаснаар нэг л болж өгдөггүй. Тэгэхэд ихэнх нь шантардаг.

Ихэнх хүмүүс “Шаналж эсэргүүцлээ гээд яах ч аргагүй тул зовлонгоос чадварлаг зайлсхийж, аль болох амар хялбар аргаар нэг насыг туулья” гэсэн бодолдоо автдаг биз ээ. Өөрөөр хэлбэл өөрийгөө хөгжүүлэх хичээл зүтгэлээс шантарч, амар хялбар амьдрал руу зугтаж орхидог байна. Нөгөөтэйгүүр ёс суртахууны үзэл ойлголтоор маруухан хүн бол “Юу ч хамаагүй хийгээд гачигдах зүйлгүй бол богинохон амьдарсан ч яахав” гэж бодохдоо нүгэлт ертөнц рүү хөл дүрэн орох нь ч бий.

Дээрхийн аль аль нь л хүний амьдралын жинхэнэ утга учраа алдсан хүмүүс юм. Учир нь тасралтгүйгээр дээшлэн дэвшиж явах нь хүн хэмээгч бодгалийн байгалийн жам бөгөөд зөв амьдралын арга билээ. Тийм байтал амьдралын зовлонд өвдөг сөгдөн, тэрхүү байгалийн жам, амьдрах зөв арга барилаа умартаж, замын дундаас буцах, арагш ухрах нь хүн болж

төрсний үнэ цэнийг өөрийн гараар үгүй хийж буй явдал юм.

### Амар тайван амьдрахын тулд

Тиймийн тул Шагжамүни бурхан бээр тэдгээр хүмүүсийн төлөө: Түр азна. Ингэвэл зовлон бэрхшээл ч, сэтгэл зовоох зүйл ч үгүй амар тайван амьдралаар амьдарч чадна хэмээн нэгэн хил хязгаарыг зааж өгчээ.

Тэр бол “Нүдэнд харагдах янз бүрийн үзэгдлүүд нь түр зуурын, хийсвэр шинжтэй тул түүнд хууртаж, сэтгэлээрээ автахгүй байвал амар тайвны хязгаарт хүрэх болно” хэмээх сургаал юм. Нэг үгээр хэлбэл “Нүдний өмнө өрнөж буй үзэгдэлд уруу татагдахгүй бай” гэсэн үг.

Үнэхээр гайхамшигтай сургаал тул хэний ч зүрх сэтгэлд “Тийм учиртай байжээ. Энэ үзэл баримтлалыг мөрдөх юм бол цаашдын амьдрал амар тайван байх боломжтой юм байна” гэсэн урам зориг оргилон гарах болно. Тэрхүү зүйрлэл ярианд гарах ахлагч нь бүхний өмнө том ордонг бий болгоод “Тэр хүртэл яваад амар” гэж хэлсэн нь дээрх хил хязгаарыг заасан хэрэг.

### Бүтээлч хийгээд эв найрамдалт амьдрал

Гэвч тэрхүү зүрх сэтгэлийн хязгаарт хүрээд сэтгэл амар болж байтал ахлагч илбийн ордонг алга болгоод, “Дахиад жаахан явахад жинхэнэ хүн ёсны утга учиртай амьдрал буй” хэмээн туйлын хүслээ илэрхийлнэ. Хүмүүс нэг хэсэг гайхсан авч тэр дороо санаагаа өөрчилж, шинэ



замаар урагшлан тэмүүлж эхэлнэ.

Тэгвэл тэрхүү “Жинхэнэ хүн ёсны утга учиртай амьдрал” гэдэг нь юу юм бол? Тэр бол “бүтээлч хийгээд эв найрамдалт амьдрал” юм.

Эхлээд хүмүүст амьдралын зовлон бэрхшээлээс ангижрахын тулд янз бүрийн амьдралын үзэгдэлд үл автахтун хэмээн сургаж, юутай ч тухайн хил хязгаарт хөтөлж, сэтгэлийн амар амгаланд хүргэнэ. Гэвч тэрхүү хил хязгаар нь гэгээрэлд хүрэх замын дундах нэгэн үе шатаас хэтрэхгүй зүйл юм. Учир нь Бурханы сургаалыг дагагч бид азаар амьдралын зовлон бэрхшээлээс ангижирч чадлаа ч, хорвоо ертөнцийн дийлэнх хүмүүс зовлон бэрхшээл дундаа байсаар л байна. Үүнийг мэдсээр байж зөвхөн өөрсдөө л амар амгалангийн хил хязгаарт байх гэдэг нь дэндүү амин хувиа хичээсэн үзэл юм. Тиймээс жинхэнэ гэгээрэл гэж хэлэх аргагүй. Бүгд хамтдаа зовж, бүгд хамтдаа аз жаргалд хүрэхийн төлөө хичээж зүтгэх явдал л хүний амьдралын жинхэнэ замнал юм. Нэг удаадаа бие сэтгэлээ амрааж, эрч хүчээр цэнэглэгдсэн бол бол тэрхүү сэтгэлээ таягдан хаяж, илбийн ордонгоос гарч, шинээр бэрхшээлийн замд орох хэрэгтэй.

Харин тэрхүү бэрхшээлт зам нь өмнө явсантай тань адил юм шиг харагдаж байлаа ч хэмжээ, цар хүрээ нь тэс ондоо байх болно. Учир нь цаашдын бэрхшээл бол бусдыг аз жаргалд хүргэх Бодисатвагийн бэрхшээл байх тул үнэ цэнэ нь ч тэнгэр газар шиг ялгаатай байх болно.

Мөн ямарваа нэг зүйлийг зовж байж бүтээх нь л хүний амьдралын утга учир гэдгийг ойлгон гэгээрч, түүнийг баяр хөөртэйгөөр хүлээн авах сэтгэлийн хязгаарт хүрсэн болохоор тэр билээ.

Ингэж хүний амьдралын хайгуулч болсон бид өөрийн зан чанар, авьяас билиг, ажил мэргэжилд тохируулан “Өөрийгөө ч, өрөөлийг ч хорвоо ертөнцийн аливаа бүхнийг ч аз жаргалд хүргэх юмс үзэгдэл”-ийг тасралтгүйгээр бүтээж явбал тэрхүү бүтээлийн үйл тань баттайяа хаа нэгтээ том эв найрамдлыг бий болгох хүчин зүйл болох болно. Тэрхүү бүтээлч ба эв найрамдал нь өөрөө хүн төрөлхтөний туйлын хүсэл билээ. (Зүйрлэшгүй үнэт зүйл)



## 12 шүтэн барилдлага ба мөргөлийн төгсгөлийн өгүүлбэр

Үүнд “Хувилгаан балгасын зүйрлэл”-ээс гадна анхаарвал зохих сургаалиуд олон янз бий. Түүн дунд “12 шүтэн барилдлага”-ийн сургаалийг дахин дурдсан ба Эсэрваа тэнгэрийн хааны уншсан шүлэгт гардаг “Энэ буяныг бүгд бээр хураах болтугай Бүх амьтан лугаа Бурханы замд орж гэгээрэх болтугай” хэмээх Бурханы олон шавь нар хурал номынхоо төгсгөлд уншдаг чухал хэсэг гардгийг мартаж үл болно.

*Нивано Никкёо “Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар /шинэ хэвлэл/”, Косей хэвлэлийн компани, 2016, X. 81-86*

**Living the**  
 **LOTUS**

## Аз жаргалд хөтлөх замаар алхах нь

Өвс ногоо дэлгэрсэн, сэтгэл сэргэсэн улирал ирлээ. 5-р сар нь уламжлалт он тооллоор бол зуны эхэн сар юм. Мөн энэ сард “ээжийн өдөр” тохиодог билээ. Амь насыг бидэнд хайрласан ээждээ талархалаа илэрхийлэх үе юм.

Мөн РКК нь жил бүр энэ сард “залуучуудын өдөр”-г зохион байгуулдаг уламжлалтай ба 50 дахь жилийн нүүрийг үзэж байна. Үүсгэн байгуулагч үргэлж залуучуудад итгэл найдлага тавьж, тэднийг дэмждэг байсан. Явсан нохой яс зууна гэдэг шиг, залуучуудыг байнга дүрэлзэн асах гал шиг хүсэл тэмүүлэлтэйгээр ямар нэг зүйлийг хийж бүтээгээсэй гэж үүсгэн байгуулагч хүсдэг байсан. Одоо цагаа эрч хүч дүүрэн амьдрах юм бол насанд ялгаа байхгүй бид бүгд залуучууд юм.

Энэ сарын Нивано ерөнхийлөгчийн сургаалаас “шуналдаа хүлэгдсэн байгаа болохоор зовлон үл тасарна” гэж суралцлаа. Санаснаар болдоггүй “зовлон”-г байгаа чигээр нь хүлээн авснаар “билиг оюун”-ыг бид хүртдэг.


Намаг балчигт ургадаг үзэсгэлэнт Бадамлянхуа адил “зовлон”-г зүрх сэтгэлийнхээ тэжээл болгон өөрийгөө илүү ахиулан хөгжүүлэхийн тулд, мөн хорвоогийн сайн сайхны төлөө, хүмүүсийн төлөө өөрийн биеийг хайрлалгүй зүтгэцгээе!

РКК, Олон улсын хэлтсийн дарга  
Сайтоо Коичи





# Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



## Rissho Kosei-kai International

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan  
 Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224  
 e-mail: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

## Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First Street, Suite #1, Los Angeles, CA 90033, U.S.A.  
 Tel: 1-323-262-4430 Fax: 1-323-262-4437  
 e-mail: info@rkina.org <http://www.rkina.org>

### Branch under RKINA

#### Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003 U.S.A.  
 Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261  
 e-mail: rkseattlewashington@gmail.com  
<http://buddhistlearningcenter.org/>

#### Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.  
 P.O. Box 692148, San Antonio, TX 78269, U.S.A.  
 Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745  
 e-mail: dharmasanantonio@gmail.com  
<http://www.rkina.org/sanantonio.html>

#### Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Road, Clearwater, FL 33764, U.S.A.  
 Tel: (727) 560-2927 e-mail: rktampabay@yahoo.com  
<http://www.buddhismtampabay.org/>

#### Rissho Kosei-kai of Vancouver

#### Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.  
 Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633  
 e-mail: info@rkhawaii.org <http://www.rkhawaii.org>

#### Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, U.S.A.  
 Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4625

#### Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740 U.S.A.  
 Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

#### Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.  
 Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567  
 e-mail: rk-la@sbcglobal.net <http://www.rkina.org/losangeles.html>

## Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado  
 Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego  
 Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas  
 Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

## Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.  
 Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-6437  
 e-mail: info@rksf.org <http://www.rksf.org>

## Rissho Kosei-kai of Sacramento

## Rissho Kosei-kai of San Jose

## Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016 U.S.A.  
 Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499  
 e-mail: rkny39@gmail.com <http://rk-ny.org/>

## Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056 U.S.A.  
 Tel: 1-773-842-5654 e-mail: murakami4838@aol.com  
<http://rkchi.org/>

## Rissho Kosei-kai of Fort Myers

<http://www.rkftmyersbuddhism.org/>

## Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112 U.S.A.  
 Tel: 1-405-943-5030 Fax: 1-405-943-5303  
 e-mail: rkokdc@gmail.com <http://www.rkok-dharmacenter.org>

## Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago Street, #809 Denver, CO 80204 U.S.A.  
 Tel: 1-303-446-0792

## Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

425 Patterson Road, Dayton, OH 45419 U.S.A.  
<http://www.rkina-dayton.com/>

## Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,  
 CEP 04116-060 Brasil  
 Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377 Fax: 55-11-5549-4304  
 e-mail: rissho@terra.com.br <http://www.rkk.org.br>

## Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,  
 CEP 08730-000 Brasil  
 Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377



**Rissho Kosei-kai of Taipei**

4F, No. 10 Hengyang Road, Zhongjheng District,  
Taipei City 100, Taiwan

Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433  
<http://kosei-kai.blogspot.com/>

**Rissho Kosei-kai of Tainan**

No. 45, Chongming 23rd Street, East District,  
Tainan City 701, Taiwan

Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

**Korean Rissho Kosei-kai**

6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420,  
Republic of Korea

Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696  
*e-mail:* krkk1125@hotmail.com

**Korean Rissho Kosei-kai of Busan**

3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea  
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

**International Buddhist Congregation (IBC)**

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan

Tel: 81-3-5341-1230 Fax: 81-3-5341-1224

*e-mail:* ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibrk-rk.org/>

**Branches under the Headquarters****Rissho Kosei-kai of Hong Kong**

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road,  
North Point, Hong Kong, Republic of China

**Rissho Kosei-kai of Ulaanbaatar**

15F Express tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,  
Ulaanbaatar 15160, Mongolia

Tel: 976-70006960 *e-mail:* rkkmongolia@yahoo.co.jp

**Rissho Kosei-kai of Sakhalin**

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk  
693005, Russian Federation

Tel & Fax: 7-4242-77-05-14

**Rissho Kosei-kai Friends in Shanghai****Rissho Kosei-kai of South Asia Division**

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang  
Bangkok 10310, Thailand

Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218

**Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)**

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang  
Bangkok 10310, Thailand

Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218

*e-mail:* thairissho@csloxinfo.com

**Branches under the South Asia Division****Rissho Kosei-kai of Delhi**

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,  
New Delhi 110060, India

**Rissho Kosei-kai of Kolkata**

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094,  
West Bengal, India

**Rissho Kosei-kai of Kolkata North**

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,  
West Bengal, India

**Rissho Kosei-kai of Bodhgaya**

Ambedkar Nagar, West Police Line Road  
Rumpur, Gaya-823001, Bihar, India

**Rissho Kosei-kai of Kathmandu**

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur, Kathmandu,  
Nepal

**Rissho Kosei-kai of Phnom Penh**

#201E2, St 128, Sangkat Mittapheap, Khan 7 Makara,  
Phnom Penh, Cambodia

**Rissho Kosei-kai of Patna****Rissho Kosei-kai of Singapore****Thai Rissho Friendship Foundation**

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang  
Bangkok 10310, Thailand

Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218

*e-mail:* info.thairissho@gmail.com

**Rissho Kosei-kai of Bangladesh**

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh

Tel & Fax: 880-31-626575

**Rissho Kosei-kai of Dhaka**

House#408/8, Road#7(West), D.O.H.S Baridhara,  
Dhaka Cant.-1206, Bangladesh

Tel & Fax: 880-2-8413855

**Rissho Kosei-kai of Mayani**

Mayani(Barua Para), Post Office: Abutorab, Police Station:  
Mirshari, District: Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Patiya**

Patiya, sadar, Patiya, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Domdama**

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Cox's Bazar**

Ume Burmese Market, Main Road Teck Para, Cox'sbazar,  
Bangladesh

**Rissho Kosei-kai of Satbaria**

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Laksham**

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,  
Bangladesh

**Rissho Kosei-kai of Raozan**

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Chendirpuni**

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Ramu****Rissho Kosei Dhamma Foundation, Sri Lanka**

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka

Tel: 94-11-2982406 Fax: 94-11-2982405

**Rissho Kosei-kai of Habarana**

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

**Rissho Kosei-kai of Polonnaruwa****Branches under the Headquarters****Rissho Kosei-kai di Roma**

Via Torino, 29-00184 Roma, Italia

Tel & Fax: 39-06-48913949 *e-mail:* roma@rk-euro.org

**Rissho Kosei-kai of the UK****Rissho Kosei-kai of Venezia****Rissho Kosei-kai of Paris**